



Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 9 тоот Хавсралт 3

## ХУДАЛДАА, ХӨГЖЛИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсгийн 76.1.13 дахь заалтыг удирдлага болгон Худалдаа, хөгжлийн банк (цаашид “Банк” гэх)-ны Гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлага, түүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлж, томилох, гэрээ байгуулах, ажлыг нь тайлагнах үйл ажиллагаа болон түүний цалин урамшуулалтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гүйцэтгэх захирал нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Банкны дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-тэй байгуулсан гэрээ (цаашид “гэрээ” гэх)-нд заасан эрх хэмжээний хүрээнд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах, Банкнийг төлөөлөн хэлцэл хийх, гэрээ байгуулах зэргээр Банкны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс баталсан дүрэм, журам, заавар, Банкны дүрэм, энэхүү Журам, Банкны дотоодод мөрдөгдөж буй бодлого, заавар, журам, Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн шийдвэрийг мөрдөж ажиллана.

### Хоёр. Гүйцэтгэх удирдлага

- 2.1. Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 2.2. Банкны Гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхгүй.
- 2.3. ТУЗ нь Гүйцэтгэх захирлыг Монголбанкны зөвшөөрснөөр өөрийн тогтоосон хугацаагаар томилох бөгөөд томилолтын хугацаа нь 1 (нэг) жилээс доошгүй байна.
- 2.4. Гүйцэтгэх захирал нь Банкны эрх бүхий албан тушаалтан<sup>1</sup> байх бөгөөд ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин, ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 2.5. Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, Банкны дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна.
- 2.6. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал, нөхөн олговор, ногдох хариуцлага зэрэг асуудлыг Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусган ТУЗ-өөс тогтооно.

<sup>1</sup> “Эрх бүхий албан тушаалтан” гэдэгт Банкны ТУЗ, Банкны албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог албан тушаалтан, Банкны дүрэмд эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон этгээдүүд болон хариуцан гүйцэтгэж буй ажил үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар эрх бүхий этгээдээр тогтоогдсон этгээдүүдийг ойлгоно.

- 2.7. Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно.
- 2.8. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн байхыг хориглох бөгөөд гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байна.
- 2.9. Гүйцэтгэх удирдлага нь Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо болон Аудитын хорооны хуралд гагцхүү эдгээр хороодын хүсэлтээр оролцоно.

### **Гурав. Гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага**

- 3.1. Гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс баталсан дүрэм, журам, заавар болон Банкны дүрэмд заасан шаардлагыг хангасан байна.
- 3.2. Гүйцэтгэх захирал нь энэ зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 3.2.1. зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
  - 3.2.2. эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
  - 3.2.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь Банкныг удирдахад харшлахгүй байх;
  - 3.2.4. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;
  - 3.2.5. зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
  - 3.2.6. санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх;
  - 3.2.7. банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
  - 3.2.8. Банк, Банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд<sup>2</sup> биш байх;
  - 3.2.9. бусад банк, түүний нэгдэл, эсхүл Банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
  - 3.2.10. Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;
  - 3.2.11. мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;
  - 3.2.12. банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй.

### **Дөрөв. Цалин хөлс, шагнал урамшуулал**

<sup>2</sup> "Нэгдмэл сонирхолтой этгээд" гэдэгт Компанийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт заасан Банкны хамаарал бүхий этгээдүүдийг ойлгоно.

4.1. Гүйцэтгэх захиралд олгох цалин хөлс, шагнал урамшууллыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос тогтоосон дээд хязгаарын хүрээнд, ТУЗ болон Гүйцэтгэх захирлын хооронд байгуулагдсан гэрээгээр тогтооно.

#### **Тав. Тайлан тэнцэл**

5.1. Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үр дүнг жилийн эцсийн тайлан хэлэлцэх үед ТУЗ дүгнэнэ.

5.2. Гүйцэтгэх захирал Үнэт цаасны бүртгэлийн журам болон хууль тогтоомж, Банкны холбогдох дүрэм, журамд заасан шаардлага, мэдээлэл бүхий тайланг Банкны жилийн үйл ажиллагааны тайлан батлагдахаас өмнө ТУЗ-д хүргүүлнэ.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1. Энэхүү Журам болон Банкны дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн Гүйцэтгэх удирдлагын үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй бол Банк хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

6.2. Гүйцэтгэх захирал энэхүү Журам болон Банкны дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээх эсэхээс үл хамаарч Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээж, бусдад учруулсан хохирол, гэм хорыг Иргэний хуульд заасны дагуу арилгана.

6.3. Гүйцэтгэх удирдлага энэхүү журам, Банкны дүрэм, түүнтэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, зохих ёсоор биелүүлээгүй, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаж ажиллаагүй тохиолдолд ТУЗ нь түүнтэй байгуулсан гэрээг дүгнэж, зохих хариуцлагыг ногдуулах ба цуцлах хүртэлх арга хэмжээ авна.

6.4. Гүйцэтгэх удирдлага нь энэхүү Журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдлээрээ Банк, түүний харилцагчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхэд хохирол учруулсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан арилгана.

6.5. Гүйцэтгэх удирдлага нь Банкны ажил хэргийн нэр хүндэд гэм хор учруулсан бол уг гэм хорыг өөрөө хариуцан арилгана.